



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Авдар өргөө ХХК-ийн “Жэй” зочид буудлын 20/405, Итгэлт түнш ХХК “Ланд” зочид буудлын 20/404, Драгон финанс ХХК-ийн “Хотел Драгон” зочид буудлын 20/403, Огторгуйн цаг ХХК-ийн “Хас” дэн буудлын 20/412, Манкур ХХК-ийн “Манкур” дэн буудлын 20/415, Маргад оньс ХХК-ийн “Номуун” амралтын газрын 20/321, ЭСДЛ ХХК-ийн “Цэцээ гүн” амралтын газрын 20/320 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

1150500302

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 10
дугаар сарын 21-ний өдрийн А/72
дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Зүүнбаян рефайнери ХХК	2637634	Пийс бридж	ХУД-ийн 1-р хороо, Дунд голын гудамж 47
2	Авдар өргөө ХХК	5234476	Жэй	СБД-ийн 1-р хороо, Автозамчдын гудамж 34
3	Итгэлт түнш ХХК	2791293	Ланд	БГД-ийн 6-р хороо, Амарсанаагийн гудамж 54 тоот
4	Жи Пи Пи Эм ХХК	6543065	Маргад	ЧД-ийн 5-р хороо, Их тойруу
5	Багануур сувилал ХХК	2009439	Багануур сувилал	БД-ийн 3-р хороо, Нацагдоржийн гудамж
6	Драгон финанс ХХК	5809037	Хотел Драгон	СХД-ийн, 29-р хороо, Москвагийн гудамж, 4-р хороолол 71

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 10
дугаар сарын 21-ний өдрийн А/2
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

5284325 СБТ-8936 1118262502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнхням шигтгээ ХХК	2664402	Мөнх-Оюу	СХД-ийн, 27-р хороо, Толгойт 22 тоот
2	Агаагийн хайр ХХК	2834375	Фамили	БЗД-ийн, 2-р хороо, Мамбадацан АОС 47 тоот
3	Огторгуйн цаг ХХК	5064635	Хас	БГД-ийн, 20-р хороо, Товчооны зам 25-2
4	Пийсвинд ХХК	5059089	Алтан говь	ЧД-ийн 1-р хороо, 1-40000 13-2
5	Манкур ХХК	2881039	Манкур	БГД-ийн 16-р хороо, Туулын 19-386
6	Эс пи сервис ХХК	2572516	Баялаг	БЗД 17-р хороо Цахлийн 189-2
7	Жэй ай өү ХХК	5531365	Сайхан хангай	СХД-ийн 27-р хороо Агарын 1-15

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 10
дугаар сарын 21-ний өдрийн А72
дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Маргад оньс ХХК	2069458	Номун	СХД-ийн 34-р хороо, Баянголын ам 384
2	ЭСДЛ ХХК	5131117	Цэцээ гүн	БЗД-ийн 11-р хороо, Богд уул Төр хурахын ам
3	Баянхадат тур ХХК	2584476	Батхаан	НД-ийн 6-р хороо, Баргын өвөлжөө

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР